



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/265

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Улсын Их хурлын 2015 оны “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай” 12-р тогтоолын 1.3.5, Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.9, 5.1.6, 5.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам” 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Боловсролын салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүй удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Стратеги, бодлого төлөвлөлтийн газар /Ж.Ганбаатар/, Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийн явцад жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

142010929

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 20... оны ... дугаар сарын ... -ний
өдрийн дугаар тушаалын хавсралт

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Боловсролын салбарын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/ бүрдүүлэх, ашиглах, хадгалах, хамгаалах, мэдээлэл солилцох, шинэчлэн баяжуулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 “Мэдээллийн сан” гэж боловсролын салбарын хүний нөөц, суралцагч ба түүний мэдээлэл, сургалтын орчин, үйл явц, үр дүн, баримт бичиг, тайлан, мэдээ, үзүүлэлт болон салбарын бусад мэдээллийн нэгдлийг хэлнэ.

1.3 Мэдээллийн санг боловсролын салбарын мэдээллийн систем болон бусад эх үүсвэрээр дамжуулан бүрдүүлнэ.

1.4 Боловсролын салбарын мэдээллийн систем гэж бүх шатны боловсролын байгууллага, сургалтын орчин, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн мэдээллийг бүртгэх, тайлан, мэдээ боловсруулах, хяналт тавих зориулалт бүхий программ хангамж, сүлжээний дэд бүтэц болон техник хангамжийн нэгдлийг ойлгоно.

1.5 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

1.6 Боловсролын салбарын мэдээллийн сангийн хөгжүүлэлт, тогтвортой ажиллагаа болон түүний зохицуулалтыг Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ хариуцан ажиллана.

Хоёр. Мэдээллийн сан

2.1. Мэдээллийн сан нь дараах дэд мэдээллийн сантай байна. Үүнд:

2.1.1. Сургуулийн өмнөх боловсролын салбар;

2.1.2. Бага, дунд боловсролын салбар;

2.1.3. Мэргэжлийн боловсролын салбар;

- 2.1.4. Дээд боловсролын салбар;
- 2.1.5. Насан туршийн боловсролын салбар;
- 2.2. Мэдээллийн санг дараах байгууллага бүрдүүлнэ:
 - 2.2.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “яам” гэх/;
 - 2.2.2. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага;
 - 2.2.3. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага;
 - 2.2.4. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага;
 - 2.2.5. Насан туршийн боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага;
 - 2.2.6. Боловсролын үнэлгээний байгууллага;
 - 2.2.7. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага;
 - 2.2.8. Боловсролын зээлийн сан;
 - 2.2.9. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага.

Гурав. Мэдээллийн сан бүрдүүлэх

- 3.1. Мэдээллийн сан бүрдүүлэхдээ Төрийн болон албаны нууцын тухай болон Монгол Улсын бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.
- 3.2. Энэхүү журмын 2.2-т заасан байгууллага тус бүр нь мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэн баяжуулах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 3.3. Энэхүү журмын 2.2-т заасан байгууллага тус бүр нь ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг тусган хариуцсан чиг үүрэг бүхий ажилтныг томилж, үр дүнг тогтмол үнэлдэг байна.
- 3.4. Энэхүү журмын 2.2-т заасан байгууллага тус бүр нь мэдээллийн сан бүрдүүлэхдээ статистик болон нэмэлт мэдээллийг үзүүлэлт, маягт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд шинэчлэн бүртгэж, хянаж баталгаажуулан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

- 3.5. Иргэн, хуулийн этгээд нь мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээ, тоо баримт болон бусад мэдээлэлд залруулга хийх хүсэлтээ нотлох баримтын хамт тус журмын 2.2-д заасан холбогдох байгууллагад гаргана.
- 3.6. Холбогдох байгууллага нь энэхүү журмын 3.5-д заасан хүсэлтийг хүлээн авч, нотлох баримтад үндэслэн мэдээллийн санд залруулга хийж, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллагад илгээж асуудлыг шийдвэрлүүлж болно.
- 3.7. Яам дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- 3.7.1. Мэдээллийн санг бүрдүүлэх, нэгтгэх, хадгалах, мэдээллийг байршуулах, нийтэд хүртээмжтэй болгох үйл ажиллагаанд Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг баримтлан ажиллах;
- 3.7.2. Энэхүү журмын 2.2.2-2.2.8-т заасан байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, баталгаажуулах, ашиглахтай холбоотой гэрээ байгуулж, үр дүнг жил бүр дүгнэх;
- 3.7.3. Мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах үүднээс төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 3.7.4. Яам нь нэг эх үүсвэртэй мэдээллийг ашиглах, мэдээллийн давхцыг арилгаж, алдааг багасгах боломжийг бүрдүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- 3.8.1. Өөрийн болон харьяа байгууллага, нэгж, сургуулийн өмнөх, бага, дунд, насан туршийн боловсролын сургалтын байгууллагуудтай мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, ашиглахтай холбогдсон гэрээ байгуулж, үр дүнг жил бүр дүгнэх;
- 3.8.2. Мэдээллийн санд бүртгэн оруулсан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг бүрэн хариуцна.
- 3.8.3. Мэдээллийн хамралт, хугацаа, үнэн зөв, бодит байдлыг хангах зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ хийх, арга зүйн болон зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.9. Энэхүү журмын 2.2.3-2.2.8 -т заасан байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.9.1. Мэдээллийн санд бүртгэн оруулсан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг байгууллагын удирдлага бүрэн хариуцна.

3.9.2. Өөрийн болон харьяа алба, нэгжээс бүртгэсэн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хянаж баталгаажуулан яаманд тогтоосон хугацаанд илгээх;

3.10. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.10.1 Бүх шатны сургалтын байгууллага нь анхан шатны мэдээлэлд хяналт тавьж ажиллана.

3.10.2 Мэдээллийн санд бүртгэн оруулсан мэдээллийн эх үүсвэр, хамралт, үнэн зөв, бодит байдлыг бүрэн хариуцна.

3.10.3 Дээд шатны байгууллагад тайлан, мэдээ, мэдээллийг хариуцсан албан тушаалтан /захирал, эрхлэгч/ хянан баталгаажуулан тогтоосон хугацаанд илгээнэ.

Дөрөв. Мэдээллийн санг ашиглах

4.1. Мэдээллийн сан дахь төрийн болон албаны нууцын тухай хуулиар хориглосноос бусад мэдээлэл нийтэд нээлттэй байна.

4.2. Яам нь мэдээллийн сангаас зохих журмын хүрээнд мэдээлэл авах, ашиглах боломжийг бүрдүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгоход дэмжлэг үзүүлнэ.

4.3. Энэхүү журмын 2.2-т заасан байгууллагууд нь мэдээллийн санг хуулиар хориглосноос бусад хүрээнд ашиглана.

4.4. Яам нь мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээ, мэдээллийг баталгаажуулан төрийн болон албаны нууцын тухай хуулиар тогтоосон болон гэрээний үндсэн дээр бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцоно.

4.5. Батлагдсан журам, загварын дагуу мэдээллийн санд үндэслэн 2.2-т заасан байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, тодорхойлолт гаргаж болно.

4.6. Энэхүү журмын 2.2-т заасан байгууллагуудын мэдээллийн сан ашиглах үйл ажиллагаанд яам нь хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

Тав. Бусад

5.1. Мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах ажиллагаа нь Төрийн болон албаны нууцын

тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”, мэдээллийн аюулгүй байдал, технологийн талаарх бусад хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна.

- 5.2. Энэ журмын 2.2-т заасан байгууллагууд нь мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг хариуцсан чиг үүрэг бүхий ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд мэдээллийн сан ашиглах хэм хэмжээ, мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой заалтыг тусгасан байна.
- 5.3. Мэдээллийн сан ашиглах чиг үүрэг бүхий ажилтан нь албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглах болон гуравдагч этгээдэд дамжуулахыг хатуу хориглох бөгөөд хувь хүн, Төрийн болон албаны нууцыг задруулсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.
- 5.4. Албан ёсны статистикийн мэдээ, тайлан, тооллого, бүртгэлийг хамрагдвал зохих байгууллагуудаас бүрэн авч гаргаагүй, буруу гаргасан, графикт хугацаа баримтлаагүй, аж ахуйн нэгж, байгууллагад заавал хөтлөгдөх анхан шатны болон нягтлан бодох, статистик бүртгэлийн нийтлэг маягт, аргачлалыг мөрдүүлэх ажлаас зайлсхийсэн буруутай хүмүүст зөрчлийн шинж байдлыг харгалзан улсын байцаагчийн акт тогтоох буюу “Захиргааны хариуцлагын тухай” хуулийг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.
- 5.5. Мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, ашиглахад энэхүү журмыг зөрчсөн, бүртгэлийн мэдээллийг хуурамчаар хөтөлсөн, зөвшөөрөлгүй ашигласан гэм буруутай этгээдэд холбогдох хуульд тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.6. Энэхүү журмын 2.2-т заасан байгууллагууд нь мэдээллийг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах чиглэлээр ажилтан, албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулж, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.